



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/182/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046.36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.19 № 124
таныг _____ ны № _____

ЯРУУ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Н.ЛОСОЛМАА-Д

Бөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэг нь хөрөнгө оруулалтаар болон бусад хандивлагчдаас нийлүүлэгдсэн 28,411.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэлийг данс бүртгэлд бүртгэсэн байна. Тус цэцэрлэг нь 6670 м.кв газрын гэрчилгээтэй бөгөөд 2519 м.кв газрыг 5,038.0 төгрөгөөр үнэлж, байгууллагын бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэсэн, 4151 м.кв газрыг үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын гол асуудал

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 102 нэр төрлийн 49,102.7 мянган төгрөгийн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, зардлын эдийн засгийн ангилал гүйлгээ зарцуулсан, байгууллагын эзэмших газрыг бүртгэлд дутуу тусгасан, шилэн дансанд байршуулах мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Яруу сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 95 хувьтай байна. Тайлант

D:\disk\Албан бичиг\Дүгнэлт

онд 15 орон тоотой 490,926.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 488,047.9 мянган төгрөгийн зарцуулалттай, 19,527.8 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй ажиллажээ. Өмнөх оны 3,561.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан боловч ажиллагсадтай холбоотой 2,037.3 мянган төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89,300,973.83	92,892,267.69
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	16,648,853.80	19,527,763.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	16,648,853.80	19,527,763.80
3121	Төгрөг	16,648,853.80	19,527,763.80
31211	Төрийн сангийн харилцах	16,648,853.80	19,527,763.80
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	-
33	АВЛАГА	3,561,126.14	-
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	3,561,126.14	-
35	БАРАА МАТЕРИАЛ	69,090,993.89	73,364,503.89
351	Түүхий эд материал	181,500.00	-
35130	Эм боох материал	181,500.00	-
354	Хангамжийн материал	68,909,493.89	73,364,503.89
35410	Бичиг хэргийн материал	443,750.00	821,400.00
35420	Аж ахуйн материал	63,283,040.89	68,016,380.89
35460	Хүнсний материал	4,087,883.00	3,431,903.00
35470	Бусад хангамжийн материал	1,094,820.00	1,094,820.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	335,490,752.57	340,362,213.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	335,490,752.57	340,362,213.32
392	Биет хөрөнгө	330,280,877.57	335,324,213.32
39201	Барилга, байгууламж	354,067,637.00	354,067,637.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(63,226,363.80)	(75,871,636.56)
39205	Машин, тоног төхөөрөмж	52,770,193.00	67,501,553.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,752,339.07)	(34,347,198.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,400,409.80	51,080,409.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,647,959.88)	(28,469,184.84)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,362,757.50	8,362,757.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,161,646.98)	(7,468,313.70)
39217	Номын фонд	468,190.00	468,190.00
393	Биет бус хөрөнгө	5,209,875.00	5,038,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39302	Хасагдуулга	(1,478,125.00)	(1,650,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,038,000.00	5,038,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	424,791,726.40	433,254,481.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	2,037,316.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	2,037,316.00
413	Өглөг	0.00	2,037,316.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	2,037,316.00
4136	Бусад өглөг	0.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	424,791,726.40	431,217,165.01
51	Засгийн газрын хувь оролцоо	424,791,726.40	431,217,165.01
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	418,508,960.38	418,508,960.38
51101	Өмч: -Төрийн өмч	418,508,960.38	418,508,960.38
512	Хуримтлагдсан үр дүн	(58,330,924.42)	(51,905,485.81)
51210	Өмнөх үеийн үр дүн	(58,330,924.42)	(58,330,924.42)
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,425,438.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,613,690.44	64,613,690.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	424,791,726.40	433,254,481.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	375,228,300.00	521,789,160.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,200,000.00	30,862,360.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,200,000.00	30,862,360.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	44,200,000.00	30,862,360.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	44,200,000.00	30,862,360.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	331,028,300.00	490,926,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	298,704,200.00	455,331,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	298,704,200.00	455,331,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,324,100.00	35,595,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,324,100.00	35,595,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	359,351,935.25	515,363,721.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	359,351,935.25	515,363,721.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,586,434.73	515,363,721.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	240,294,074.00	384,469,684.00
210101	Цалин	172,138,894.00	226,220,273.00
210102	Нэмэгдэл цалин	49,707,437.00	143,235,673.00
210104	Урамшуулал	18,447,743.00	15,013,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,734,135.49	38,836,258.14
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,317,822.18	24,649,861.14
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,520,111.56	3,536,694.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,016,089.63	1,768,346.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	839,882.30	1,768,346.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,040,229.82	7,113,011.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,922,699.48	32,338,324.40
210301	Гэрэл цахилгааны зардал	3,121,858.48	3,322,724.40
210302	Түлш, халаалтын зардал	27,238,341.00	28,259,600.00
210303	Цэвэр, бохир усны зардал	562,500.00	756,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,290,403.92	5,158,260.00
210401	Бичиг хэргийн материал	1,443,600.00	3,737,200.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	2,846,803.92	1,421,060.00
2105	Нормативт зардал	22,913,666.00	24,432,670.00
210501	Эм	-	181,500.00
210502	Хоол	22,913,666.00	24,251,170.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,383,575.60
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,383,575.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	483,800.00	1,085,500.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	483,800.00	1,085,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,947,655.84	25,659,449.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,398,720.00	2,119,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,548,935.84	23,539,899.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,765,500.52	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,765,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,765,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.52	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.52	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	15,876,364.75	6,425,438.61
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	15,876,364.75	6,425,438.61

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	331,028,300.00	490,926,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	331,028,300.00	490,926,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	298,704,200.00	455,331,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	298,704,200.00	455,331,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	32,324,100.00	35,595,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,324,100.00	35,595,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	341,618,236.00	488,047,890.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,618,236.00	488,047,890.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	339,852,735.48	488,047,890.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	240,294,074.00	382,432,368.00
210101	Үндсэн цалин	172,138,894.00	226,220,273.00
210102	Нэмэгдэл	49,707,437.00	141,198,357.00
210104	Үр дүнгийн урамшуулал	18,447,743.00	15,013,738.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	35,398,382.00	35,275,132.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,982,068.69	21,088,735.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,520,111.56	3,536,694.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,016,089.63	1,768,346.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	839,882.30	1,768,346.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,040,229.82	7,113,011.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	30,324,099.48	32,595,000.00
210301	Гэрэл цахилгааны зардал	3,121,858.48	3,762,300.00
210302	Түлш, халаалтын зардал	26,302,241.00	27,932,700.00
210303	Цэвэр, бохир усны зардал	900,000.00	900,000.00
2105	Нормативт зардал	22,081,380.00	23,595,190.00
210502	Хоол, хүнс	22,081,380.00	23,595,190.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,000,000.00
2106	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	483,800.00	1,085,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	483,800.00	1,085,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,271,000.00	10,064,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,641,400.00	7,057,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,629,600.00	3,007,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,765,500.52	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,765,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,765,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.52	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.52	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(10,589,936.00)	2,878,910.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	649,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	649,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	649,900.00	-

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	649,900.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(649,900.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(11,239,836.00)	2,878,910.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,888,689.80	16,648,853.80
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,648,853.80	19,527,763.80

**ӨМЧИЙН
ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	418,508,960.38	64,613,690.44	(58,330,924.42)	424,791,726.40
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	418,508,960.38	64,613,690.44	(58,330,924.42)	424,791,726.40
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	6,425,438.61	6,425,438.61
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	418,508,960.38	64,613,690.44	(51,905,485.81)	431,217,165.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	16,648,853.80	(16,648,853.80)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	452,786,000.00	452,452,890.00	333,110.00	99.93
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	452,786,000.00	452,452,890.00	333,110.00	99.93
Бараа, үйлчилгээний зардал	452,786,000.00	452,452,890.00	333,110.00	99.93
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	371,295,500.00	382,432,368.00	(11,136,868.00)	103.00
Үндсэн цалин	227,286,400.00	226,220,273.00	1,066,127.00	99.53
Нэмэгдэл	138,236,500.00	141,198,357.00	(2,961,857.00)	102.14
Урамшуулал	5,772,600.00	15,013,738.00	(9,241,138.00)	260.09
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,412,000.00	35,275,132.00	11,136,868.00	76.00
Тэтгэврийн даатгал	31,560,100.00	21,088,735.00	10,471,365.00	66.82
Тэтгэмжийн даатгал	3,713,000.00	3,536,694.00	176,306.00	95.25
ҮОМШӨ ний даатгал	1,856,500.00	1,768,346.00	88,154.00	95.25
Ажилгүйдлийн даатгал	1,856,500.00	1,768,346.00	88,154.00	95.25
Эрүүл мэндийн даатгал	7,425,900.00	7,113,011.00	312,889.00	95.79
Нормативт зардал	23,771,900.00	23,595,190.00	176,710.00	99.26

Хоол, хүнс	23,771,900.00	23,595,190.00	176,710.00	99.26
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	988,400.00	1,085,500.00	(97,100.00)	109.82
Мэдээллийн технологийн зардал	988,400.00	1,085,500.00	(97,100.00)	109.82
Бараа үйлчилгээний бусад зардал	10,318,200.00	10,064,700.00	253,500.00	97.54
Бараа үйлчилгээний бусад зардал	7,330,400.00	7,057,600.00	272,800.00	96.28
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,987,800.00	3,007,100.00	(19,300.00)	100.65
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	437,046,200.00	455,331,800.00	(18,285,600.00)	104.18
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	437,046,200.00	455,331,800.00	(18,285,600.00)	104.18
Улсын төсвөөс санхүүжих	437,046,200.00	455,331,800.00	(18,285,600.00)	104.18
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	16,648,853.80	(16,648,853.80)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,527,763.80	(19,527,763.80)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,595,000.00	35,595,000.00	-	100.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	35,595,000.00	35,595,000.00	-	100.00
Бараа, үйлчилгээний зардал	35,595,000.00	35,595,000.00	-	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,595,000.00	32,595,000.00	-	100.00
Гэрэл цахилгаан	3,762,300.00	3,762,300.00	(0.00)	100.00
Түлш, халаалт	27,932,700.00	27,932,700.00	-	100.00
Цэвэр, бохир ус	900,000.00	900,000.00	-	100.00
Эд хогшил худалдан авах	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,595,000.00	35,595,000.00	-	100.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,595,000.00	35,595,000.00	-	100.00
Орон нутгийн төсвөөс	35,595,000.00	35,595,000.00	-	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөснөөс 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай”, “цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх” зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 8,462.9 мянган төгрөгөөр буюу 1.02 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	16,648.80	19,527.70	2,878.90
Авлага	3,561.10		(3,561.10)
Бараа материал	69,090.90	73,364.50	4,273.60
Үндсэн хөрөнгө	335,490.70	340,362.20	4,871.50
Нийт хөрөнгө	424,791.50	433,254.40	8,462.90
Өр төлбөрийн дүн		2,037.30	2,037.30
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	424,791.70	431,217.10	6,425.40
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	424,791.70	433,254.40	8,462.70

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 2,878.9 мянган төгрөгөөр, бараа материал 4,273.6 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 4,871.5 мянган төгрөгөөр, өглөг 2,037.3 мянган төгрөгөөр тус тус өсч, авлага 3,561.1 мянган төгрөгөөр буурчээ.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 69,090,9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 35,303.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 2,451.0 мянган төгрөгийн аж ахуйн материал хандив тусламжаар хүлээн авч, 33,481.4 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр 73,354.5 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооллогын бүртгэл хөтөлж, тооцоог бодсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 28,411.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг хандив тусламжаар орлогот авч бүртгэлд тусгажээ. Тайлант онд 23,539.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант оны эцэст авлага өмнөх оны 3,561.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан боловч 2,037.3 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 471,071.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 35,595.0 мянган төгрөгөөр, нийт 506,666.6

мянган төгрөг, зардлыг 506,666.6 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын болон орон нутгийн төсвөөс 490,926.8 мянган төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 488,047.9 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байна. Энэ нь тайлант оны төсвийг хоол хүнсний зардал 176.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 253.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж бусад зардлыг 100 хувь зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр ага хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71801	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	471,071.6	452,452.9	18,618.7	96.0
80233	Хүүхэд хамгааллын зардал	397.9	397.9	0	100
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	788.2	788.2	0	100
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	24,281.9	23,595.2	686.7	97.2
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1,850.9	1,850.9	0	100
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	689.5	689.5	0	100
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	441,077.4	423,145.4	17,932.0	95.9
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	1,985.8	1,985.8	0	100
Дүн		471,071.6	452,452.9	18,618.7	96.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
80109	Тогтмол зардал	35,595.0	35,595.0	0	100
Нийт дүн		506,666.6	488,047.9	18,618.7	96.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 35,595.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 32,595.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 3,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл

5 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагатай нийт 7 гэрээ /шууд аргаар/	Хоол хүнс	22,081.3	23,595.2
ДҮН		22,081.3	23,595.2

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар тооцож, 5,390.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 4,042.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Яруу сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Хоолны нормативыг мөрдөн ажиллаж, сар бүр хоолны зардлын хэтрэлт, хэмнэлт гаргахгүй байх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 756.0 мянган төгрөгийн алдаа илэрч, 756.0 мянган төгрөгийн зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж:

1. 2024 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлд 2519 м.кв газар тоологдсон нь дансан дахь бусад биет бус хөрөнгийн дүнтэй тохирч байгаа бөгөөд байгууллагын газрын гэрчилгээнд байгаа газрын хэмжээнээс 4151 м.кв-аар дутуу байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1-д “Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.-д “Үнэн зөв байх” зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Газрын хэмжээ, үнэлгээг хянаж, бүртгэлд бүрэн тусгах зөвлөмж өгөв.

2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 102 нэр төрлийн 49,102.7 мянган төгрөгийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдсэн үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй

нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шитгэлээрээ анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Дээрхи хөрөнгийг акталж устгах, дахин үнэлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.Аудитын ажлын төлбөрийг зардлын ангилал зөрүүлж цэвэр бохир усны зардлаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7 "төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, шаардлагатай тохиолдолд төсөвт холбогдох журмын дагуу зохицуулалт хийж байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ОЮУНСҮВД
Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

БОЛОВСРҮҮЛСАН:



Огноо: 2025-02-24

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-НИЙ АУДИТОР

Р.МЯДАГМАА

Огноо: 2025-02-19